

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

Нэг. Өсвөр насны хүүхдийн эрх зүйн байдлыг нь Эрүүгийн хуульд дордуулж зохицуулсан асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-иар гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг өмнөх хуулиас дордуулж зохицуулсан нь практикт нэлээдгүй асуудал дагуулж, 18 нас хүрээгүй хүүхдийг аль болохоор хорихоос өөр ялаар шийтгэх хувилбарыг баримтлах олон улсын гэрээ, конвенци, пактын зарчимд нийцээгүй асуудал болоод байна.

2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүүхдийн хувьд гэмт хэргийн ангилал харгалзахгүйгээр “хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх”, “хорих ял оногдуулах шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах” зэрэг зохицуулалт байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар эдгээрийг зөвхөн “хөнгөн гэмт хэрэг” гэж хязгаарласан нь өмнө байсан энэрэнгүй зохицуулалтыг дордуулсан байна.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 8.1 дэх “Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл” зүйлийн 4 дэх заалт “Хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр энэ бүлэгт заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэж болохгүй” гэж заасан нь “хүнд гэмт хэрэг” гэх ангилалд хамаарах гэмт хэрэгт холбогдсон л бол заавал хорих ялаар шийтгэхээр зохицуулагдаад байна.

Эрүүгийн хуулиар гэмт хэргийг “хөнгөн” ба “хүнд” хэмээн ангилж буй ангилал нь насанд хүрэгсдийн үйлдэж буй гэмт хэргийн шинж чанар, хор хохирол болон бусад шинж чанарыг нь үндэслэж ангилсан ангилал бөгөөд үүнийг насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт шууд хамааруулан авч үзэх нь учир дутагдалтай. Хүүхдийн үйлдэж буй гэмт хэргийн ихэнх нь оюун санаанд нь нийгэмд харш үзэл бодол хэвшил болон тогтсоноос шалтгаалаагүй, харин тухайн цаг үеийн нөхцөл байдал, болж буй үзэгдлийг зөв үнэлж, түүнтэй холбогдуулж өөрийнхөө явуулж буй үйлдлийн нийгмийн хор уршгийг богино хугацаанд бүрэн гүйцэд ойлгож, үнэлэх дадлага туршлага, чадвар дутсантай холбоотой байдаг байна. Иймээс ч олон улсын хэмжээнд “насанд хүрээгүй хүүхдийн шүүн таслах ажиллагаа” гэх нэр томъёог хэрэглэж, гэмт хэрэгт яллагдаж, сэжиглэгдэж байгаа хүүхдийн шүүх ажиллагааг насанд хүрэгсдийн ерөнхий процессоос ялгаатай хэрэглэдэг байна.

Тодорхой жишээ дурдахад, өсвөр 14-17 насны 4 хүүхэд хүнсний дэлгүүрээс 110 мянган төгрөгийн талх, боорцог, чихэр гэх мэт хүнсний зүйл хулгайлсан ба Эрүүгийн хуулийн Хулгайлах гэмт хэргийн тусгай ангийн 17.1

зүйлийн 2.1 дэх заалт “хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч гэмт хэрэг үйлдсэн” хэмээх зүйл ангиар яллагдсан. Энэ зүйл анги нь “хүнд” гэмт хэргийн ангилалд багтдаг тул дээрх хүүхдүүд хорих ялаар шийтгүүлээд байгаа ба эдгээр хүүхдүүдийн хувьд бусдын дарамт шахалтаар анх удаа ийм үйлдэл хийсэн, үйлдэлдээ гэмшиж байгаа, бага хэмжээний хохирол учруулсан, хохирлыг даруй барагдуулсан, эцэг эх сургуулийн зүгээс тэдгээрийг батлан даах хүсэлтээ илэрхийлсэн гээд харгалзан үзэх хувийн нөхцөл байдлууд байгаа хэдий ч өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөж буй Эрүүгийн хуулиар тэдгээрт оногдуулсан хорих ялыг өөрчлөх боломж байхгүй болоод байна.

Улсын хэмжээнд 2017 онд 32,259 гэмт хэрэг бүртгэгдсэнээс насанд хүрээгүй хүнээс үйлдсэн 948 гэмт хэрэг бүртгэгдсэн ба эдгээрийн дийлэнх нь хулгайн гэмт хэрэг гэсэн статистик байна. Цагдаагийн байгууллагаас хүүхдийг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт ажил зохион байгуулж буй хэдий ч хүүхдээс үйлдэж байгаа энэ төрлийн гэмт хэргийн гаралт төдийлөн буурахгүй байна.

Энэ төрлийн гэмт хэргийн үндсэн шалтгаан нөхцөл нь эцэг эхийн хайр халамж дутах, амьдралын түвшин доогуур байх, ядуурал ажилгүйдэл, гуйланчлал, тэнүүчлэл, бусад хүмүүсийн муу нөлөө, гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрсэн болон арай ахмад насны хүүхдүүдийн зүгээс гэмт хэрэг үйлдэхийг шаардан дарамтлах, согтуурал, мансуурал, хэвлэл мэдээллийн сөрөг нөлөө, багш сурган хүмүүжүүлэгч, сургуулийн зүгээс таагүй харьцаа зэрэг олон төрлийн нийгмийн сөрөг үзэгдлүүд болж байна. Түүнчлэн үе тэнгийнхэндээ уруу татагдан, арга мэх, дарамт шахалтанд нь автан гэмт хэрэг үйлдэх тохиолдол ч цөөнгүй байна.

Ингэж амьдралд байр сууриа олох гэж тэмтчиж явахдаа эрх зүйн зөрчил гаргаж, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийн хувийн нөхцөл байдал, гэмт хэрэгт анх удаа холбогдсон байдал, учруулсан хор хохирлын ноцтой байдал зэргийг харгалзаж үзэлгүй, насанд хүрэгсдийн гэмт хэргийн “хөнгөн”, “хүнд” гэсэн нийтлэг ангилалд нийцүүлэн хорих ял оноож байгаа нь тэдгээрийн эрх зүйн байдлыг дордуулж байна.

Хоёр. Өсвөр насны хүүхдийн эрх зүйн байдлыг нь Эрүүгийн хуульд дордуулж зохицуулсан асуудлын зохицуулалтыг шийдвэрлэх зорилго, зохицуулалтын хувилбар

Зорилго: Өсвөр насны хүнийг үйлдсэн гэмт хэргийнх нь шинж чанар, гэм буруугийн зарчимд нийцүүлэн шүүж, ял онооно, аль болохоор ял оноохгүйгээр шийдвэрлэнэ гэсэн зарчим баримтлах нь хамгийн шударга, зөв, энэрэнгүй зохицуулалт болно.

Зохицуулалтын хувилбар:

Хувилбар – 1: Хуулийн өнөөгийн зохицуулалтыг хэвээр үлдээж, өсвөр насны хүнийг гэмт хэрэгт холбогдохгүй байх тал дээр урьдчилан соён гэгээрүүлэх арга хэмжээ авч ажиллах

Өсвөр нас гэдэг бол хүний хүүхэд наснаасаа насанд хүрсэн хүн рүү шилжих бүхэл бүтэн үеийг хэлнэ. Энэ үедээ зөв төлөвшихөд нь гэр бүл, хамт олон, сургууль, нийгэм гэдэг олон зүйл нөлөөлнө. Манай улсын нийгэм, эдийн засгийн өнөөдрийн нөхцөл байдал өсвөр насныхныг зөв төлөвшин тогтнох орчинг бүрдүүлж өгч чадахгүй байгаа. Ялангуяа ядуурал, ажилгүйдэл газар авсан энэ цаг үед хичнээн ч соён гэгээрүүлээд бид энэ асуудлыг арилгаж чадахгүй, нийгмийн нөхцөл байдал сайжиртал энэ асуудал байсаар байх болно. Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийг шоронд явуулснаар хүмүүжүүлнэ гэж байхгүй, харин ч тэр хүүхэд ирээдүйд улам л эргэлзээтэй хүмүүжилтэй, ёс зүйтэй хүн болж төлөвшин тогтнох суурийг бий болгох аюултай.

Иймд Хувилбар -1 нь асуудлыг шийдвэрлэх зорилгыг хангаж чадахгүй бөгөөд шоронжсон хүүхдийн бүхэл бүтэн нэг үеийг бий болгох аюул дагуулах магадлалтай.

Хувилбар – 2: Хуульд өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж, тус хуулийн зарим зүйл заалтыг хүчингүй болгож, зарим зүйл заалтад өөрчлөлт оруулна. Тухайлбал,

Эрүүгийн хуулийн 8.1 дэх зүйлийн 3 дах хэсэг “Хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр энэ бүлэг заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэж болохгүй” гэсэн заалтыг хүчингүй болгоно.

Насанд хүрэгсдийн гэмт хэргийн “хүнд” гэх ангилалыг өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгт шууд авч хэрэглэх нь учир дутагдалтай. Иймээс ч олон улсын хэмжээнд “насанд хүрээгүй хүүхдийн шүүн таслах ажиллагаа” гэх нэр томъёог хэрэглэж, гэмт хэрэгт яллагдаж, сэжиглэгдэж байгаа хүүхдийн шүүх ажиллагааг насанд хүрэгсдийн ерөнхий процессоос ялгаатай хэрэглэдэг. Хүүхдийн эрхийн конвенци олон улсын гэрээний дагуу улс бүр нь хүүхдийн ашиг сонирхлыг дээд зэргээр хамгаалах үүрэг хүлээж, хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт нь нийцүүлэн арга хэмжээ авах, түүний хувийн нөхцөл байдлыг тусгайлан авч үзэхийг шаарддаг. Үүнийг тусгайлан авч үзэж, түүнд нь тохирсон арга хэмжээ авахын оронд заавал хорих ял оноож, шоронд явуулахаар шийтгэнэ гэж зохицуулж буй нь хүүхдэд нэн харгис хандсан хэрэг болохоос гадна манай улсын зүгээс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж буй явдал юм.

Үүнтэй уялдуулан өсвөр насны хүнд ногдуулж буй эрүүгийн хариуцлагыг “хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх”, “хорих ял оногдуулах шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах” хөнгөлөлтийг гэмт хэргийн ангилал харгалзахаар байгаа дараах зүйл заалтуудад өөрчлөлт оруулна. Үүнд,

Эрүүгийн хуулийн 8.6 дах “Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах” зүйлийн 1 дэх заалтын “хөнгөн” гэснийг хасна.

Эрүүгийн хуулийн 8.7 дах “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ” зүйлийн 1 дэх заалтын “хөнгөн” гэснийг хасна.

Гурав. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал

3.1 Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө, Эдийн засагт үзүүлэх үр нөлөө, Нийгэмд үзүүлэх үр нөлөө, Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу гарган, тандсан байдлыг Хавсралт хүснэгтүүдээс үзнэ үү.

3.2 Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал

Монгол улсын Үндсэн хууль болон Монгол улсын олон улсын гэрээнд нийцсэн, аливаа хэлбэрээр зөрчилдөөн үүсгээгүй, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх, гэр бүл, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалах зарчмыг хангахад чиглэсэн хэмээн дүгнэж байна.

Дөрөв. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалсан байдал

Манай улс “Хүүхдийн эрхийн тухай конвенци”-д 1990 онд нэгдэн орсон ба тус Конвенцид хүлээн зөвшөөрсөн хүүхдийн эрхийг ханган ажиллаж байгаа талаар НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт 5 жил тутамд ирүүлдэг дүгнэлт, зөвлөмжид дараах нийтлэг асуудлууд дурдагдаж ирсэн. Үүнд:

- 18 нас хүрээгүй хүмүүсийг хорих ялын хугацааг хуулиар богиносгох;
- 18 нас хүрээгүй хүмүүсийг урьдчилан хорих байранд байлгах хугацааг хуулиар богиносгох, аргагүй тохиолдолд зөвхөн шүүгчийн зөвшөөрөлтэйгөөр аль болох бага хугацаагаар хорих, хорьсны дараа хугацааг заавал шалгаж үзэх;

- 18 нас хүрээгүй хүмүүсийг хорихоос өөр ялаар шийтгэх хувилбарууд, тухайлбал тэнсэн харгалзах, олон нийтийн ажил хийлгэх, ялыг хойшлуулах зэрэг хувилбарыг хөгжүүлэх;
- Хорихоос өөр ял оноохоос аргагүй тохиолдолд баривчлах, хорих үйл ажиллагааны нөхцөлийг сайжруулах;
- 18 нас хүрээгүй хүмүүс зохих хууль зүйн тусламж, өмгөөлөгч авах боломж олгох, бусдаас хамааралгүйгээр, хүүхдэд ээлтэй нөхцөлд мэдүүлэг өгөх механизм бүрдүүлэх;

Иймд манай улсыг насанд хүрээгүй хүний хэргийг авч хэлэлцэх стандартууд, тухайлбал Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан “Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шүүн таслах ажиллагаа явуулахтай холбоотой наад захын дүрэм” (Бээжингийн дүрэм), “Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын үндсэн зарчим ” (Риядийн үндсэн зарчим), “Эрх чөлөө нь хязгаарлагдсан насанд хүрээгүй хүнийг хамгаалах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын журам, “ Гэмт хэргийн улмаас хуулийн системд байгаа хүүхдэд үзүүлэх арга хэмжээний тухай” Венийн дүрэм болон Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 37, 40, 39 дүгээр зүйл гэх мэт насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хамгаалах стандартыг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарахыг шаарддаг байна.

Хүүхдийн эрхийн конвенцийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 оны 11 дүгээр сарын 20-нд баталснаас хойш 193 орон нэгдэн ороод байгаа хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн олон улс орон баталсан хүний эрхийн хэлэлцээр байгаа юм. Тус конвенцид нэгдэн орсон улс орнуудын ихэнх нь гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг аль болохоор хорих ял оноохгүйгээр, хүүхдийг эргэн нийгэмшүүлэх чиглэлийн шийтгэл оноохыг урьтал болгох хууль эрх зүйн тусгайлсан зохицуулалтыг мөрддөг.

Гэтэл манай улс насанд хүрээгүй хүүхдийн хувьд гэмт хэргийн ангилал харгалзахгүйгээр хорих ял оногдуулсан шийтгэлийг тэнсэх, хойшлуулах зохицуулалт байсныгаа Эрүүгийн шинэ хуулиар зөвхөн “хөнгөн гэмт хэрэг” гэж хязгаарлан, өмнөх зохицуулалтаасаа ухарч, дордуулаад байна.

Тав. Зохицуулалтын хувилбарыг харьцуулсан дүгнэлт

Манай улс гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүүхдэд хорих ял оногдуулсан шийтгэлийг гэмт хэргийн ангилал харгалзахгүйгээр тэнсэх, хойшлуулах зохицуулалттай байсныгаа Эрүүгийн шинэ хуулиар зөвхөн “хөнгөн гэмт хэрэг” гэж хязгаарласан нь өмнөх зохицуулалтаасаа ухарсан, өсвөр насны хүний эрх зүйн байдлыг илт дордуулсан байна.

Иймд **Хувилбар – 2** –т заасны дагуу Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, тус хуулийн зарим зүйл заалтыг хасах, зарим зүйл заалтад өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Зургаа. Зөвлөмж

Насанд хүрээгүй хүний шүүн таслах ажиллагааны тогтолцооны хүрээнд хүүхдийн сайн сайхныг харгалзаж, дээдлэх ёстой бөгөөд насанд хүрээгүй хууль зөрчигчдөд авах арга хэмжээ нь түүний үйлдсэн зөрчил, тухайн хүүхдийн нөхцөл байдалтай уялдах ёстой.

Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн үйлдэл нь ихэвчлэн хүүхдийн төлөвших нэг хэсэг бөгөөд олон тохиолдолд хүүхдийг насанд хүрснээр алга болдог гэдгийг ч харгалзах нь зүйтэй.

Улс нь хүүхдийнхээ биеийн болон сэтгэл санааны сайн сайхан байдлыг дэмжиж, энэ нь алдагдсан тохиолдолд эргээд засан хүмүүжүүлэх талдаа илүү анхаарч, хүүхдийн цаашдаа нийгэмших, нийгэмд гүйцэтгэх үүргийг нь харгалзан үзэх ёстой.

Иймд гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн эрх зүйн байдлыг нь дордуулж зохицуулсан Эрүүгийн хуулийн 8.1 дэх “Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл” зүйлийн 4 дэх заалт “Хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр энэ бүлэгт заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэж болохгүй” гэж заасан заалтыг хүчингүй болгож, тус хуулийн 8.6 дах “Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах” зүйлийн 1 дэх заалтын болон тус хуулийн 8.7 дах “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ” зүйлийн 1 дэх заалтын “хөнгөн” гэснийг тус тус хасч өөрчлөлт оруулах зүйтэй.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1 Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш эрх			
	1.1.1 Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	
	1.1.2 Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	
	1.1.3 Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Өсвөр насны хүний эрх зүйн байдлыг дээрдүүлнэ.
	1.2 Оролцоог хангах			
	1.2.1 Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Иргэд Үндсэн хуульд заасан эрхээ эдлэх боломжтой.
	1.2.2 Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Иргэд, холбогдох байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал дээр үндэслэсэн.
	1.3 Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1 Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх хангагдах баталгаа бүрдэнэ.
	1.3.2 Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хүн бүр тэгш эрхтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

	1.3.3 Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Холбогдох хуулиар зохицуулагдана.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1 Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	
	2.2 Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	
3. Эрх агуулагч	3.1 Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Өсвөр насны хүн, тэдгээрийн хууль ёсны асран хамгаалагч
	3.2 Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.3 Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	
	3.4 Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	
4. Үүрэг хүлээгч	4.1 Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1 Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	
	5.2 Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх	1.1 Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй

чадвар	хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх			
	1.2 Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	1.3 Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1 Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	2.2 Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	2.3 Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	2.4 Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1 Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.2 Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.3 Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.4 Бараа бүтээгдэхүүний борлуулалтанд ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.5 Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1 Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй

5. Өмчлөх эрх	5.1 Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	5.2 Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	5.3 Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
6. Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1 Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	6.2 Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1 Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	7.2 Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	7.3 Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	7.4 Хувь хүний /гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Өрхөд ирэх нэмэлт ачаалал алга болно.
8. Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1 Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	8.2 Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	8.3 Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
9. Төрийн захиргааны байгууллага	9.1 Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	9.2 Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй

	өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх			
	9.3 Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
10. Макро эдийн засгийн хүрээнд	10.1 Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	10.2 Хөрөнгө оруулалтын нөхцлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	10.3 Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
11. Олон улсын харилцаа	11.1 Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1 Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	1.2 Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	1.3 Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	1.4 Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлсөн эсэх	Тийм	Үгүй	Сайнаар нөлөөлнө
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1 Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	2.2 Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.3 Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй

	2.4 Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	2.5 Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1 Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	3.2 Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх, Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	3.3 Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1 Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	4.2 Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	4.3 Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	4.4 Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	4.5 Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1 Хувь хүн / нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	5.2 Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй

	5.3 Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглэгээ)-г нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1 Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	6.2 Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	6.3 Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	6.4 Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	6.5 Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1 Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	7.2 Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	7.3 Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	7.4 Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
8. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	8.1 Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.2 Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	8.3 Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Агаар	1.1 Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1 Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх /бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	2.2 Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	2.3 Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	2.4 Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1 Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	3.2 Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	3.3 Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	3.4 Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
4. Усны нөөц	4.1 Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй
	4.2 Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	4.3 Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

5. Хөрсний бохирдол	5.1 Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	5.2 Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
6. Газрын ашиглалт	6.1 Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	6.2 Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	6.3 Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
7. Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1 Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй
	7.2 Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй

АШИГЛАСАН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА, ГАРЫН АВЛАГА, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЭМХЭТГЭЛ

Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага:

1. НҮБ-ын Хүний эрхийн хорооны дүгнэлт, зөвлөмж – 2005 он
2. НҮБ-ын Хүний эрхийн хорооны дүгнэлт, зөвлөмж – 2010 он
3. НҮБ-ын Хүний эрхийн хорооны дүгнэлт, зөвлөмж – 2015 он
4. “Шударгаар шүүлгэх эрх”, гарын авлага, Эмнести Интернэшнл олон улсын байгууллага
5. “Эрүүгийн хуучин ба шинэ хуулийн зөрлөгт үүссэн ээдрээ, эмгэг, эсрэгцэл”, Хуульч Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, Шүүх эрх мэдэл сэтгүүл, Тусгай дугаар, 2007, №2
6. “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, Шүүгч З.Тунгалагмаа, <https://www.slideshare.net/ankhbilegluvsan/ss-47541931>

Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, тушаалын жагсаалт:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Хууль тогтоомжийн тухай хууль
3. Монгол Улсын Олон улсын гэрээ, Хүүхдийн эрхийн тухай конвенци
4. Эрүүгийн хууль